



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 35

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах,  
үндсэн хөрөнгөд үнэлгээ тогтоож,  
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Дундговь-Ус” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 57,817,516.30 /тавин долоон сая найман зуун арван долоон мянга таван зуун арван зургаан төгрөг гучин мөнгө/ төгрөгийн балансын үнэтэй 30,788,800.53 /гучин сая долоон зуун наян найман мянга найман зуун нэг/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй нэгдүгээр хавсралтад дурдсан 11 нэр төрлийн 11 ширхэг үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, 15,017,267.42 /арван таван сая арван долоон мянга хоёр зуун жаран долоо/ төгрөгийн балансын үнэтэй 4,617,487.71 /дөрвөн сая зургаан зуун арван долоон мянга дөрвөн зуун наян найм/ төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий 1 ширхэг барилга, 3 ширхэг тээврийн хэрэгслийн худалдах доод үнийг хоёрдугаар хавсралтад заасны дагуу тогтоон нээлттэй дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар (Б.Адъяасүрэн)-д даалгасугай.

3. “Дундговь-Ус” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга (О.Бархүү)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

3.1 Дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах;

3.2 Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг акталж, акталснаас гарсан материалыг эргэлтийн хөрөнгөд бүртгэх;

3.3 Үл хөдлөх хөрөнгийг акталж, акталснаас гарсан хог хаягдлыг цэвэрлэж, чөлөөлсөн газрыг нөхөн сэргээж байгууллагын хэрэгцээнд зориулалтаар нь ашиглах;

3.4 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

3.5 Энэ тогтоолын биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ




Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн өдрийн  
35 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын дуудлага худалдаанд оруулах хөрөнгийн мэдээлэл

д/д	Хөрөнгийн нэр	Ашигла лтад орсон он	хэмж их нэгж	тоо хэмж ээ	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Дуудах анхны үнэ
1	Ус цэнгэгийн барилга	1998	м2	1	2,245,467.42	2,245,467.42	1,416,782.75	828,684.67	1,500,000.00
2	Тээрийн хэрэгсэл 95- 64 дуа	2006	ш	1	3,500,000.00	3,500,000.00	1,195,833.47	2,304,166.53	2,500,000.00
3	тээрийн хэрэгсэл 61- 14 дуа	2011	ш	1	7,771,800.00	7,771,800.00	6,287,163.49	1,484,636.51	1,500,000.00
4	тээрийн хэрэгсэл 37- 36 дуа	2006	ш	1	1,500,000.00	1,500,000.00	1,500,000.00	-	1,000,000.00
				4	15,017,267.42	15,017,267.42 /арван таван сая арван долоон мянга хоёр зуун жаран долоон төгрөг дөчин хоёр мөнгө/	10,399,779.71 /арван сая гурван зуун ерэн есөн мянга долоон зуун далан есөн төгрөг далан нэгэн мөнгө/	4,617,487.71 /дөрвөн сая зургаан зуун арван долоон мянга дөрвөн зуун наян долоон төгрөг далан нэгэн мөнгө/	6,500,000.00 /зургаан сая таван зуун мянга/ төгрөг

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн  
35 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын актлах хөрөнгийн мэдээлэл

д/д	Хөрөнгийн нэр	Ашигла лтанд орсон огноо	хэмж их нэгж	тоо хэмж ээ	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдса н элэгдэл	Үлдэгдэл өртөг	Данснаас хасах болсон шалтгаан
1	3-р гүний худгийн барилга	2009	ш	1	4,548,001.50	4,548,001.50	519,771.84	4,028,229.66	Эх үүсврийн тоног төхөөрөмж суурилуулсан барилга нь гүний ус олборлох боломжгүй мэрэгжлийн байгууллагын дүгнэлтээр газрын гүйдэл таарч суулгалтын шугамыг мургуйлгадаг учир ашиглах боломжгүй болсон /2удаагийн тохиолдлоор/
2	2-р өргөх насосны ажлын байр	2009	ш	1	281,722.40	281,722.40	160,984.32	120,738.08	Өргөх станцын операторийн ажлын байрын зориулалттай баригдсан байсан ашиглах боломжгүй /үнсэн блок/
3	3-р өргөх насосны ажлын байр	2009	ш	1	280,881.62	280,881.62	160,503.84	120,377.78	Өргөх станцын операторийн ажлын байрын зориулалттай баригдсан байсан ашиглах боломжгүй /үнсэн блок/
4	Дизелийн барилга	2009	ш	1	1,405,128.00	1,405,128.00	344,736.00	1,060,392.00	Нөөцийн генаторын зориулалттай барилга ашиглагдах боломжгүй
5	Складны барилга	1976	ш	1	10,098,459.00	10,098,459.00	2,885,274.24	7,213,184.76	бараа материалын хадгалах зориулалттай аж ахуйн аргаар баригдсан барилга дээвэр хаалга хана гэмтсэн шаардлага хангахгүй болсон
6	Хлор станцын барилга	2009	ш	1	10,328,959.62	10,328,959.62	2,295,324.48	8,033,635.14	Аймгийн төвийн ус ханган нийлүүлэгдэх резерварийн усыг хлоржуулах тоног төхөөрөмж суурилжуулсан зориулалттай байгууламж нь суурь суулттай хана цуурсан дээвэр

7	6001 эх үүсврийн резерварь	2009	ш	1	3,344,104.84	3,344,104.84	477,729.12	2,866,375.72	Олборлосон ус дамжуулах зориулалтын нөөцийн сав төмөр листэн материалтай дөрвөлжин хэлбэртэй 1.5тн-ны багтаамжтай. Резерварь нь газар доор булаатай байх ба дотор нь зэвэрч цоорсон учир ашиглах боломжгүй. Олборлолтыг шугаманд холбож шууд нийлүүлэлт хийгддэг болсон
8	Санхүүгийн программ	2011	ш	1	691,000.00	691,000.00	691,000.00	-	Веница нягтлан бодох бүртгэлийн программыг ашиглахгүй байгаа сайжруулсан программ Юниукс -г ашиглаж байгаа
9	3-р гүний худаг	2009	ш	1	18,451,898.00	18,451,898.00	11,106,030.61	7,345,867.39	Олгойн говьд байрлалтай цэвэр ус олборлох эх үүсвэр нь мэрэгжлийн байгууллагын дүгнэлтээр газрын гүйдэл таарч суулгалтын трубаг 2 удаагийн тохиолдлоор мургуйлгадаг учир ашиглах боломжгүй болсон
10	Уурын зуухны яндан	2011	ш	1	8,005,815.00	8,005,815.00	8,005,815.00	-	галд сорогдон голоороо хугарсан
11	Цэвэрлэх байгууламжийн барилга	2003	ш	1	381,546.32	381,546.32	381,546.32	-	шинэ цэвэрлэх байгууламж ашиглалтанд орсон тул цаашид ашиглагдахгүй
				11	57,817,516.30	57,817,516.30	27,028,715.77	30,788,800.53	
<b>Нийт</b>					<b>57,817,516.30</b> /тавин долоон сая найман зуун арван долоон мянга таван зуун арван зургаан төгрөг гучин мөнгө/ төгрөг	<b>57,817,516.30</b> /тавин долоон сая найман зуун арван долоон мянга таван зуун арван зургаан төгрөг гучин мөнгө/ төгрөг	<b>27,028,715.77</b> /хорин долоон сая хорин найман мянга долоон зуун арван таван төгрөг далан долоон мөнгө/ төгрөг	<b>30,788,800.53</b> /гучин сая долоон зуун наян найман мянга найман зуун төгрөг тавин гурван мөнгө/ төгрөг	